



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/181

Жавхлант

Г Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.8.1, 9.8.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Овоо сумын Дэлгэрхаан багийн нутаг Хавтгай хар гэх газар намаржиж байгаа Пүрэвийн Оюунбатын суурьт 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр аймгийн Мал эмнэлгийн газраас ирсэн 242 дугаартай бичгээр лабораторийн шинжилгээгээр эерэг гарч гоц халдварт шүлхий өвчин батлагдаж ирсэн тул тус газарт 10км-т 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Голомт болон сэжигтэй бүсэд байгаа айл өрхийн судалгааг хавсралтаар баталсугай.

3.Тарилгад хамруулах малын тоо, сэжигтэй бүс нутагт байгаа малчдад мэдээ, мэдээлэл хүргэх, цаг үеийн ажлын зураглалыг гаргахыг Дэлгэрхаан багийн Засаг дарга (Х.Энх-Уянга)-д даалгасугай.

4.Шаардагдах вакцин, эм бэлдмэл болон ариутгалын бодис татан авч, мэргэжил арга зүйгээр хангаж, эрсдэлийн үнэлгээний асуумж авч дүгнэлт гаргах, тарилгын явцын дүн мэдээг холбогдох газарт хүргүүлж, халдварт өвчин гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг чанартай зохион байгуулж ажиллахыг Эх цаг ХХК-ийн малын эмч (Ч.Нацаг)-, Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Г.Шижирбаатар) нарт тус тус даалгасугай.


5.Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүсээс гарах мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэл, иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, өвчний эх үүсвэр, шалтгаан нөхцөлийг тогтоох,

хөдөлгөөнт эргүүл ажиллуулахыг сумын хэсгийн төлөөлөгч, Цагдаагийн дэслэгч (Г.Ганбаяр)-т үүрэг болгосугай.

6.Голомтот бүсийн хилийн зааг болон гол чиглэлийн авто зам дээр таних тэмдэг байршуулах хөдөлгөөн хязгаарлаж хяналын цэг байршуулж хавсралтад заагдсан хуваарийн дагуу 24 цагаар эргүүлд гарахыг сумын цагдаа Дэд ахлагч (Н.Анхбаяр) болон багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7.Өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг өдөр бүр "Мал, амьтны гоц халдварт өвчнийг яаралтай мэдээлэх журам"-н дагуу аймгийн Мал эмнэлгийн газарт мэдээлэхийг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч (Г.Шижирбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Г.ЭНХЗАЯА